

**Өндөр хурдны телеграфын 2022 оны Улсын Аварга  
шалгаруулах тэмцээний заавар.**

**Нэг. Тэмцээний зорилго.**

1. Радио спортыг олны хүртээл болгон сурталчлах,
2. Радио спортыг сонирхон суралцах шинэ залуу тамирчдыг нэмэгдүүлэх
3. Спортын дээд амжилтыг бүртгэх, спортын цол зэрэг олгох

**Хоёр. Тэмцээний зохион байгуулалт.**

1. Тэмцээнийг Монголын Радио Спортын Холбооноос томилогдсон шүүгчдийн бүрэлдэхүүн зохион байгуулж явуулна.
2. Тэмцээн 2022 оны 12-р сарын 9, 10-нд 10:00 цагт Мандах Наран төвд болно.
3. Техникийн зөвлөгөөн 12-р сарын 09-ны 9:30-д тэмцээний байранд болно. Оролцох тамирчдын мэдүүлгийг 12 сарын 5-ны 17 цагаас өмнө [jt1cs@mrsf.mn](mailto:jt1cs@mrsf.mn) хаягаар хүлээн авах ба хоцорсон баг тамирчид тэмцээнд оролцох боломжгүй.
4. Тэмцээний хураамж тамирчин тус бүр 40,000 төгрөг ба мэдүүлгийн хамт төлсөн байна. Хураамжийг дараах дансанд төлнө: Худалдаа хөгжлийн банк, Монголын Радио спортын холбоо 499080329 тоот данс. Мэдүүлэгч тамирчны овог нэр, оролцох ангилал, спортын цол зэрэг, Регистрийн дугаар зэргийг бичнэ.
5. Тэмцээнийг Эрэгтэй /насны хязгаарлалтгүй/, Эмэгтэй А ангилал /39 насны буюу 1983 оны 12 сарын 09-нөөс хойно төрсөн/, Эмэгтэй Б ангилал /40-өөс дээш насны буюу 1982 оны 12 сарын 09-нөөс өмнө төрсөн/ ангилалуудаар дараах төрлүүдээр зохион байгуулна.

Үүнд:

- Хүлээн авалт /үсэг, тоо, холимог/
- Нэвтрүүлэг /үсэг, тоо, холимог/
- RUFZ,
- Morse Runner

Жич: Ангилал бүрт доод тал нь 5 тамирчин оролцох тохиолдолд уг ангилалын тэмцээнийг явуулна.

**Гурав. Тэмцээнд оролцогчид.**

1. Тэмцээнд радио спортоор сонирхон хичээллэдэг хот дүүргийн баг, албан байгууллага, клубүүд, хилийн цэрэг, зэвсэгт хүчний анги салбарууд, их дээд, тусгай мэргэжлийн, ерөнхий боловсролын сургуулиудын баг тамирчид, хувь хүмүүс оролцож болно.
2. Тэмцээнд оролцох тамирчин хувийн бэлтгэлийг сайтар хангасан байх шаардлагатай. Үүнд: Чихэвч, нэвтрүүлэх түлхүүр, ноорог цаас, үзэг харандаа гм.
3. Morse Runner, RUFZ дасгалд хувийн keyboard ашиглахгүй.
4. Тэмцээнд тамирчид багаар болон хувиар оролцож болох ба байгууллагаас орох багийн тоог хязгаарлахгүй.
5. Баг нь эрэгтэй, эмэгтэй А, Б ангилалуудаас тус бүр нэг нэг тамирчны бүрэлдэхүүнтэй байна. Нэг байгууллага хэдэн ч багтай байж болно. Тухайн байгууллагад ажилладаггүй тамирчныг байгууллагын багт оруулахгүй байвал зохино.

## **Дөрөв. Тамирчны гүйцэтгэх дасгал.**

1. Тамирчин тэмцээний үед дараах дасгалуудыг хийж гүйцэтгэнэ.

А. Компьютерийн програмаар нэвтрүүлэх 5 тэмдэгт бүхий /үсэг, тоо, холимог/ группыг тус бүр НЭГ минутанд хүлээн авна.

Б. Тамирчин нэвтрүүлгийн өрөөнд 5 тэмдэгт бүхий /үсэг, тоо, холимог/ группыг автомат түлхүүрээр тус бүр НЭГ минутанд нэвтрүүлнэ.

В. Радио сонирхогчийн дуудлага хүлээх дасгалд /RUFZ/ 2 оролдлого хийх.

Г. Morse Runner, тэмцээний холбоо барих дасгалд 2 удаагийн оролдлого хийх.

## **Тав. Тэмцээнийг дүгнэх.**

### **ХҮЛЭЭН АВАЛТ.**

1. Хүлээн авалтын дасгалд үсэг, тоо, холимог текст тус бүр 10 хурдыг компьютерээс нэвтрүүлнэ.

2. Тамирчин үсэг, тоо, холимог текст хүлээн авах зөвхөн нэг удаагийн оролдлого хийнэ.

3. Тэмцээнд оролцогч өөрийн хүссэн 5 хурдыг сонгож хүлээн авна. Ж-нь: 70, 90, 100, 120, 130 гм... Хүлээн авах текстийг Компьютерийн ZEUS програмаар нэвтрүүлнэ. Програм текстийг хурд тус бүрийн дунд 1 минутын завсарлагатай нэвтэрүүлнэ.

4. Хурдыг гараар эсвэл компьютерээр бичиж болно.

5. Тамирчид өөрийн хүлээн авсан 3 хурдаа сонгож 30 минутанд багтаан хуулж шүүгчид илгээнэ. 30 минутын хугацаа дуусмагц програм автоматаар хуулсан текстийг шүүгчид илгээдэг.

6. Текстийг латин цагаан толгойгоор хуулна.

7. Хүлээн авалтын үед чихэвчинд тохиолдсон саатал, гэмтлийг тамирчин өөрөө хариуцна.

8. Хүлээн авалтын дасгалын үед зохион байгуулагчаас гаргасан техник хэрэгсэл, програмд гарсан саатлын үед хүлээн авалтын дасгалыг шинээр эхлүүлнэ.

9. Тамирчны хувийн бэлтгэлээс болж гарсан саатал 8-р зүйлд хамаарахгүй.

### **Хүлээн авалтын алдааг тооцох.**

- Өөр тэмдэгт бичсэн
- Бүлгийн доторх тэмдэгтийн байрыг сольж бичсэн бол сольсон тоогоор
- Тэмдэгт хаясан
- Илүү тэмдэгт бичсэн
- Нэг бүлгийн тэмдэгтийг өөр бүлэгт шилжүүлэн бичсэн
- Крилл латин үсэг хольж бичсэн

## **НЭВТРҮҮЛЭГ.**

1. Тамирчныг нэвтрүүлгийн өрөөнд 10 минутын хугацаанд өгөгдсөн 3 текстийг хувийн телеграфын түлхүүрээр нэвтрүүлнэ. Дахин мэдээ нэвтрүүлэх хугацаа байвал аль нэг текстээ нэвтрүүлэх 2 дах оролдлогоо хийхийг зөвшөөрнө.
2. 10 минут нь тамирчин Нэвтрүүлгийн өрөөнд орж ирсэн мөчөөс эхлэнэ.
3. Тэгийг 5 зураасаар нэвтрүүлнэ.
4. Алдсан тэмдэгтээ зөв болгон нэвтрүүлэхдээ 6-аас доошгүй үргэлжилсэн цэг нэвтрүүлж бүлгийн эхнээс давтан нэвтрүүлнэ.
5. Тамирчин нэвтрүүлгийн дасгалыг өөрийн автомат түлхүүрээр гүйцэтгэх ба нэвтрүүлгийн үед түлхүүрт гарсан гэмтлийг тамирчин өөрөө хариуцна.

### **Нэвтрүүлгийн алдааг тооцох.**

- Бүлгийн доторх тэмдэгтийн байрыг сольж нэвтрүүлэх,
- Тэмдэгт орхиж нэвтрүүлэх,
- Өөр тэмдэгт нэвтрүүлэх,
- Илүү тэмдэгт нэвтрүүлэх,

### **Нэвтрүүлэгт үнэлгээ өгөх,**

- 2 дах оролдлого хийсэн тохиолдолд аль өндөр оноо авсаныг нь тооцно.
- Нэвтрүүлгийн алдааг компьютерээр гаргах ба 2 шүүгч нэвтрүүлгийн чанарт /1, 0.9, 0.8, 0.7 үнэлгээ өгнө/

## **RUFZ XP буюу Радио сонирхогчийн дуудлага хүлээн авах дасгал.**

1. Радио сонирхогчийн дуудлага хүлээх дасгалыг RUFZ XP програмаар гүйцэтгэнэ.
2. Радио сонирхогчийн 50 дуудлага хүлээж авна.
3. Дуудлагыг аль болох хурдан, хамгийн бага хугацаанд хүлээн авна.
4. Тамирчин RUFZ XP-ын дасгалд 2 удаагийн оролдлого гүйцэтгэх ба аль өндөр оноотойг нь тооцно
5. Оноог Компьютер бодож гаргана. Хамгийн өндөр оноог 100 хувь гэх ба бага оноог түүнээс хувилж бодно.

## **MORSE RUNNER буюу тэмцээний холбоо барих дасгал.**

1. Радио сонирхогчийн уралдааны холбоо барих дасгалыг Morse Runner програмаар гүйцэтгэнэ.
2. Холбоо барих дасгалыг 10 минутын туршид гүйцэтгэнэ.
3. Тамирчин MORSE RUNNER-ын дасгалд 2 удаагийн оролдлого гүйцэтгэх ба аль өндөр оноотойг нь тооцно.
4. Оноог Компьютер бодож гаргана. Хамгийн өндөр оноог 100 хувь гэх ба бага оноог түүнээс хувилж бодно.

## **Зургаа. Байр эзлүүлэх.**

1. Тэмцээнийг Хүлээн авалт, Нэвтрүүлэг, RUFZ, Morse Runner төрөлд эрэгтэй, эмэгтэй А, Б ангилал тус бүрт болон дээрх 4 төрлийн нийлбэр дүнгээр байр эзлүүлнэ.
2. Багийн дүнгээр 1, 2, 3 дугаар байрыг эзлүүлнэ.

## **Долоо. Шагнал.**

1. Хувийн дүнгээр:

А. Нэвтрүүлэг, Хүлээн авалт, Morse Runner, RUFZ төрлүүд тус бүрт байр эзлүүлж дараах шагнал олгоно.

- 1-р байр. Алтан медаль, өргөмжлөл
- 2-р байр. Мөнгөн медаль, өргөмжлөл
- 3-р байр. Хүрэл медаль, өргөмжлөл

Б. Нэвтрүүлэг, Хүлээн авалт, Morse Runner, RUFZ төрлүүдийн нийлбэр дүнгээр Эрэгтэй, Эмэгтэй А, Б ангилал тус бүрт байр эзлүүлж дараах шагнал олгоно.

- 1-р байр. Алтан медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал
- 2-р байр. Мөнгөн медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал
- 3-р байр. Хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал

2. Багийн дүнгээр байр эзлүүлж дараах шагнал олгоно.

- 1-р байр. Цом, өргөмжлөл, медаль, мөнгөн шагнал
- 2-р байр. Өргөмжлөл, медаль, мөнгөн шагнал
- 3-р байр. Өргөмжлөл, медаль, мөнгөн шагнал

## **Найм. Санал гомдол**

1. Тэмцээний дүнгийн талаарх санал гомдлыг ерөнхий дүн гарахаас өмнө бичгээр хүлээн авна.
2. Санал гомдлын талаарх шүүгчдийн бүрэлдэхүүний шийдвэр нь эцсийн шийдвэр байх болно.

Тэмцээнтэй холбоотой асуулт байвал 91917388 утсаар холбогдоно уу.

**Ерөнхий зохион байгуулагч: Монголын Радио Спортын Холбоо**